

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/155/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ДЭЖИД ЦЭЦЭРЛЭГИЙН 2025
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

Ауд. 02. 25 № 01/198
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ДЭЖИД ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Т.БОЛОРТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэгийн бусад үндсэн хөрөнгийн дансанд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 26,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий цэвэр усны гүний худгийг тус цэцэрлэгийн өмч хамгаалах комиссын дүгнэлтийг үндэслэн сумын ЗДТГ-аас шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Сумын ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 9,621.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, эрхлэгчийн тушаалаар 5,132.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95,5 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

4126020236

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	202,863,177.80	113,498,076.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	140,588,645.40	53,408,809.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	140,588,645.40	53,408,809.80
3121	Төгрөг	140,588,645.40	53,408,809.80
31211	Төрийн сангийн харилцах	140,588,645.40	53,408,809.80
35	БАРАА МАТЕРИАЛ	62,274,532.40	60,089,266.92
354	Хангамжийн материал	62,274,532.40	60,089,266.92
35420	Аж ахуйн материал	48,690.00	-
35440	Түлш, шатах тослох материал	672,000.00	190,000.00
35460	Хүнсний материал	982,700.00	649,400.00
35470	Бусад хангамжийн материал	60,571,142.40	59,249,866.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,954,652,713.57	2,913,712,660.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,954,652,713.57	2,913,712,660.70
392	Биет хөрөнгө	2,925,840,713.57	2,884,900,660.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,890,880,902.87	2,890,880,902.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,921,431.31)	(86,039,510.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,943,095.00	52,233,275.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,877,221.86)	(37,550,291.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,529,246.50	58,034,607.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,608,992.48)	(35,711,096.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,797,300.00	51,797,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,460,890.15)	(9,930,265.88)
39217	Ном	1,558,705.00	1,185,740.00
393	Биет бус хөрөнгө	28,812,000.00	28,812,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,812,000.00	28,812,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,157,515,891.37	3,027,210,737.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,157,515,891.37	3,027,210,737.42
51	Засгийн газрын хувь оролцоо	3,157,515,891.37	3,027,210,737.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	93,618,549.95	93,618,549.95
51101	Өмч: - төрийн	93,618,549.95	93,618,549.95
512	Хуримтлагдсан үр дүн	2,971,250,641.15	2,840,945,487.20
51210	Өмнөх үеийн үр дүн	2,971,250,641.15	2,971,250,641.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	(130,305,153.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,646,700.27	92,646,700.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,157,515,891.37	3,027,210,737.42

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,326,739,105.00	689,668,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,294,781,005.00	26,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,667,437,805.00	26,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,440,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	92,440,000.00	-
122	Тусламжийн орлого	627,343,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,958,100.00	663,668,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	588,227,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	588,227,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,958,100.00	75,440,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,958,100.00	75,440,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	595,320,050.51	819,318,303.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	595,320,050.51	819,318,303.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580,491,410.91	805,187,292.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,214,270.96	525,059,260.60
210101	Үндсэн цалин	285,721,445.96	339,154,393.03
210102	Нэмэгдэл	122,824,875.00	173,600,804.51
210104	Урамшуулал	9,667,950.00	12,304,063.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,431,633.31	64,742,525.00
210201	Тэтгэврийн даатгал	35,444,556.56	44,028,445.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,767.96	5,179,970.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,056,083.97	2,590,785.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,940,086.24	2,590,785.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,872,138.58	10,352,540.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,597,642.52	58,791,789.80
210301	Гэрэл, цахилгаан	5,209,642.52	46,699,789.80
210302	Түлш, халаалт	20,036,000.00	10,134,000.00
210303	Цэвэр, бохир ус	352,000.00	1,958,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,511,430.00	17,379,175.48
210401	Бичиг хэрэг	3,712,570.00	5,053,230.00
210402	Тээвэр, шатахуун	3,921,100.00	4,613,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	114,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,763,760.00	2,580,280.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,132,265.48
2105	Нормативт зардал	58,852,650.00	59,758,790.00
210502	Хоол, хүнс	58,852,650.00	59,758,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,618,000.00	330,000.00
210702	Дотоод албан томилолт	2,618,000.00	330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,725,750.00	9,796,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,635,750.00	6,709,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	756,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	90,000.00	2,331,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,540,034.12	66,329,001.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,802,050.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,737,984.12	66,329,001.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,828,639.60	14,131,010.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,407,200.00	-

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,407,200.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,421,439.60	14,131,010.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,421,439.60	14,131,010.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,731,419,054.49	(129,650,103.06)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	655,050.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	655,050.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(655,050.89)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,731,419,054.49	(130,305,153.95)

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	659,301,300.00	663,668,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	627,343,200.00	-
122	Тусламжийн орлого	627,343,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,958,100.00	663,668,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	588,227,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	588,227,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,958,100.00	75,440,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	31,958,100.00	75,440,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	602,647,724.27	750,804,035.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,647,724.27	750,804,035.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,819,084.67	736,673,025.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,214,270.96	525,059,260.60
210101	Үндсэн цалин	285,721,445.96	339,154,393.03
210102	Нэмэгдэл	122,824,875.00	173,600,804.51
210104	Урамшуулал	9,667,950.00	12,304,063.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,431,633.31	64,742,525.00
210201	Тэтгэврийн даатгал	35,444,556.56	44,028,445.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,118,767.96	5,179,970.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,056,083.97	2,590,785.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,940,086.24	2,590,785.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,872,138.58	10,352,540.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,536,660.40	58,309,789.80
210301	Гэрэл, цахилгаан	5,209,642.52	46,699,789.80
210302	Түлш, халаалт	20,975,017.88	9,652,000.00
210303	Цэвэр, бохир ус	352,000.00	1,958,000.00
2105	Нормативт зардал	59,546,350.00	62,700,890.00
210502	Хоол, хүнс	59,546,350.00	62,700,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	900,000.00	2,472,350.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00	2,472,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,190,170.00	20,388,210.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,498,050.00	15,119,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,692,120.00	5,269,030.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,828,639.60	14,131,010.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,407,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,407,200.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,421,439.60	14,131,010.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,421,439.60	14,131,010.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	56,653,575.73	(87,135,835.60)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	44,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	44,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	44,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(44,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	56,653,575.73	(87,179,835.60)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,935,069.67	140,588,645.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	140,588,645.40	53,408,809.80

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,758,549.95	92,646,700.27	196,851,106.26	361,256,356.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,758,549.95	92,646,700.27	196,851,106.26	361,256,356.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	42,980,480.40	42,980,480.40
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,618,549.95	92,646,700.27	2,971,250,641.15	3,157,515,891.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,618,549.95	92,646,700.27	2,971,250,641.15	3,157,515,891.37
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(130,305,153.95)	(130,305,153.95)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,618,549.95	92,646,700.27	2,840,945,487.20	3,027,210,737.42

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	785,809,100.00	649,537,189.80	136,271,910.20	82.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,440,800.00	61,309,789.80	14,131,010.20	81.3
132001	Орон нутгийн төсвөөс	75,440,800.00	61,309,790.00	14,131,010.20	81.3
1310	УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ	592,035,900.00	588,227,400.00	3,808,500.00	99.4
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	592,035,900.00	588,227,400.00	3,808,500.00	99.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	118,332,400.00	-	118,332,400.00	-
1200042	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	118,332,400.00		118,332,400.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	785,941,400.00	736,717,025.40	49,224,374.60	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	785,941,400.00	736,717,025.40	49,224,374.60	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	785,941,400.00	736,717,025.40	49,224,374.60	93.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,865,600.00	525,059,260.60	27,806,339.40	95.0
210101	Үндсэн цалин	347,697,800.00	335,452,904.00	12,244,896.45	96.5
210102	Нэмэгдэл	190,387,700.00	177,302,294.00	13,085,406.01	93.1
210104	Урамшуулал	14,780,100.00	12,304,063.00	2,476,036.94	83.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,813,100.00	64,742,525.00	4,070,575.00	94.1
210201	Тэтгэврийн даатгал	46,698,500.00	44,028,445.00	2,670,055.00	94.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,528,700.00	5,179,970.00	348,730.00	93.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,764,300.00	2,590,785.00	173,515.00	93.7
210204	Ажилгүйдлийн даатгал	2,764,300.00	2,590,785.00	173,515.00	93.7
210205	Эрүүл мэндийн даатгал	11,057,300.00	10,352,540.00	704,760.00	93.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,440,800.00	58,309,789.80	14,131,010.20	80.5
210301	Гэрэл, цахилгаан	48,540,800.00	47,289,790.00	1,251,010.20	97.4
210302	Түлш, халаалт	22,700,000.00	9,652,000.00	13,048,000.00	42.5
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,368,000.00	(168,000.00)	114.0
2105	Нормативт зардал	63,769,600.00	62,700,890.00	1,068,710.00	98.3
210502	Хоол, хүнс	63,769,600.00	62,700,890.00	1,068,710.00	98.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,212,000.00	2,472,350.00	739,650.00	77.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,212,000	2,472,350	739,650.00	77.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,840,300.00	20,432,210.00	1,408,090.00	93.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,344,200.00	15,119,180.00	1,225,020.00	92.5
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	5,496,100.00	5,313,030.00	183,070.00	96.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		140,588,645.40		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		53,408,809.80		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 614,271.4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 3 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 44.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 26,000.00 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн байна
- Урсгал үйл ажиллагааны 588,227.4 мянган төгрөгийн санхүүжилтийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 5,160.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 5,703.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар нийт 5,160.3 мянган төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмж хүргүүллээ.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 243 ширхэг 53,149.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөвлөмж өгөв.

3.Зардлын дансны асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 5,160.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Энэ нь МУЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 237 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон журмыг дагуу өгөөгүй зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 44.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна.	1	44.0					1	44.0		
2	Үнэ төлбөргүй хүлээн авсан 26,000.00 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн байна.	1	26,000.0					1	26,000.0		
3	Урсгал үйл ажиллагааны 588,227.4 мянган төгрөгийн санхүүжилтийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн.	1	588,227.4					1	588,227.4		
	Дүн	3	614,271.4					3	614,271.4		

Төв аймгийн Жаргалант сумын Дэжид цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 5,160.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.	1	5,160.3							1	5,160.3				
2	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-							1	-				
3	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 243 ширхэг 53,149.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-							1	-				
	Дүн	3	5,160.3							3	5,160.3				

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn